БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

## БАЯНЦАГААН СУМЫН СУМ ДУНДЫН ЭМНЭЛГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД: БНА-2021/168/СТА-ТШЗ**

---

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424, 99442140

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429
Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /эх хувь/ ............ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан............ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ............ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ............ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ............ 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ............ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ............ 10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ............ 11
3.Аудитын тайлан ............ 12
3.1. Ерөнхий зүйл ............ 12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ............ 12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт............ 12
3.4. Материаллаг байдал ............ 13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ............ 13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт............ 14
3.7. Шилэн дансны мэдээлэл ............ 16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............ 16
3.9. Аудитын илрүүлэлт ............ 16
Залруулсан алдаа............ 16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ............ 17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд............ 17
Хавсралт: 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт............ 18

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021. 02.25 № 2/82

танай ____________ -ны №____________ -т

БАЯНЦАГААН СУМЫН СУМ
ДУНДЫН ЭМНЭЛГИЙН ЭРХЛЭГЧ
Т.ОДОНТУНГАЛАГ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90,3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

005020032

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **27,994,606.54** | **28,176,920.54** |
| **33** | **АВЛАГА** | 51,230.00 | 268,544.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 268,544.00 |
| **335** | **Бусад авлага** | 51,230.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 51,230.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 27,943,376.54 | 27,908,376.54 |
| **354** | **Хангамжийн материал** | 24,713,376.54 | 27,908,376.54 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 345,650.00 | 345,650.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 12,831,277.00 | 12,831,277.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 2,195,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 1,000,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,171,300.00 | 1,171,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,365,149.54 | 10,365,149.54 |
| 35600 | Мал амьтад | 3,230,000.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **354,609,615.23** | **1,503,329,628.47** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 354,609,615.23 | 1,503,329,628.47 |
| **392** | **Биет хөрөнгө** | 340,111,615.23 | 1,488,831,628.47 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 275,786,430.24 | 1,459,286,430.24 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -17,665,718.28 | -47,539,561.56 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 57,866,434.00 | 57,866,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -36,125,180.90 | -41,023,485.17 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 148,770,331.72 | 170,950,041.53 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -107,647,275.88 | -126,692,645.07 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,387,151.90 | 30,387,151.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,260,557.57 | -14,402,737.40 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 14,498,000.00 | 14,498,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,948,000.00 | 14,948,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **382,604,221.77** | **1,531,506,549.01** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **186,649.00** | **431,044.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 186,649.00 | 431,044.00 |
| **413** | **Өглөг** | 186,649.00 | 431,044.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 186,649.00 | 268,544.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 162,500.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 162,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **382,417,572.77** | **1,531,075,505.01** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 382,417,572.77 | 1,531,075,505.01 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 285,452,863.00 | 285,452,863.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 285,452,863.00 | 285,452,863.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -231,049,650.38 | 917,608,281.86 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -231,049,650.38 | -231,049,650.38 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,148,657,932.24 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 328,014,360.15 | 328,014,360.15 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **382,604,221.77** | **1,531,506,549.01** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **566,114,577.00** | **1,858,122,820.71** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **19,735,277.00** | **1,210,579,648.71** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 19,735,277.00 | 1,210,579,648.71 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 19,735,277.00 | 1,210,579,648.71 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 19,723,277.00 | 1,210,579,648.71 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **546,379,300.00** | **647,543,172.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 488,558,100.00 | 568,753,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 488,558,100.00 | 568,753,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 440,200.00 | 9,986,452.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 9,679,252.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 440,200.00 | 307,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 57,381,000.00 | 68,803,720.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 57,381,000.00 | 68,803,720.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **580,684,114.81** | **709,464,888.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **580,684,114.81** | **709,464,888.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 547,596,093.81 | 696,860,723.86 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 343,163,917.00 | 406,834,637.39 |
| 210101 | Үндсэн цалин | 219,433,692.00 | 242,862,394.53 |
| 210102 | Нэмэгдэл | 95,020,795.00 | 120,631,367.71 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,904,483.00 | 6,925,731.13 |
| 210104 | Урамшуулал | 23,804,947.00 | 36,415,144.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,763,910.00 | 50,964,158.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,279,839.00 | 34,868,857.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,444,689.00 | 4,068,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,755,747.00 | 3,157,559.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 687,734.00 | 889,463.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,595,901.00 | 7,979,579.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,984,873.00 | 61,875,890.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,734,679.00 | 2,282,894.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,088,250.00 | 58,841,090.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 161,944.00 | 751,906.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,167,354.00 | 28,728,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,358,100.00 | 800,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,569,760.00 | 19,818,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 50,000.00 | 350,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,619,400.00 | 2,529,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,570,094.00 | 2,000,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 3,230,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 42,179,237.00 | 71,748,813.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,927,837.00 | 61,625,613.90 |
| 210502 | Хоол, хүнс | 6,146,400.00 | 8,143,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 105,000.00 | 1,980,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,042,300.00 | 9,805,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 3,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,042,300.00 | 6,305,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,217,000.00 | 546,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,217,000.00 | 546,000.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,897,884.00 | 3,403,118.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 300,800.00 | 590,258.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 346,650.00 | 353,295.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 73,500.00 | 95,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 39,534.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,306,800.00 | 1,306,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 38,000.00 | 86,965.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 228,500.00 | 220,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 314,100.00 | 445,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 41,179,618.81 | 62,954,706.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,285,500.00 | 5,995,010.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 38,894,118.81 | 56,959,696.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 33,088,021.00 | 12,604,164.61 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | 8,197,194.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 7,597,194.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 32,448,321.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 32,448,321.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 39,700.00 | 00.00 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 39,700.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 4,406,970.61 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 4,406,970.61 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-14,569,537.81** | **1,148,657,932.24** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 10,047,916.99 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 10,047,916.99 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -10,047,916.99 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-24,617,454.80** | **1,148,657,932.24** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **546,391,300.00** | **647,543,172.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 12,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **546,379,300.00** | **647,543,172.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 488,558,100.00 | 568,753,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 488,558,100.00 | 568,753,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 440,200.00 | 9,986,452.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 9,679,252.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 440,200.00 | 307,200.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 57,381,000.00 | 68,803,720.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 57,381,000.00 | 68,803,720.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **537,001,300.00** | **647,543,172.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **537,001,300.00** | **647,543,172.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **503,913,279.00** | **634,939,007.39** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 343,476,285.00 | 406,858,786.39 |
| 210101 | Үндсэн цалин | 219,433,692.00 | 242,770,799.53 |
| 210102 | Нэмэгдэл | 95,333,163.00 | 120,747,111.71 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,904,483.00 | 6,925,731.13 |
| 210104 | Урамшуулал | 23,804,947.00 | 36,415,144.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,763,910.00 | 50,964,158.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,279,839.00 | 34,868,857.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,444,689.00 | 4,068,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,755,747.00 | 3,157,559.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 687,734.00 | 889,463.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,595,901.00 | 7,979,579.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,984,873.00 | 61,875,890.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,734,679.00 | 2,282,894.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,088,250.00 | 58,841,090.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 161,944.00 | 751,906.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,228,940.00 | 25,592,170.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,062,500.00 | 800,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,070,440.00 | 19,767,570.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 50,000.00 | 495,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,502,200.00 | 2,529,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,543,800.00 | 2,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 44,998,437.00 | 63,506,875.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,927,837.00 | 53,383,675.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,146,400.00 | 8,143,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,924,200.00 | 1,980,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,214,300.00 | 14,398,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 5,898,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,214,300.00 | 8,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,217,000.00 | 546,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,217,000.00 | 546,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,977,884.00 | 5,202,118.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 300,800.00 | 2,389,258.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 346,650.00 | 353,295.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 73,500.00 | 95,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 39,534.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,306,800.00 | 1,306,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 38,000.00 | 86,965.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 228,500.00 | 220,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 394,100.00 | 445,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,051,650.00 | 5,995,010.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,051,650.00 | 5,995,010.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **33,088,021.00** | **12,604,164.61** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | 8,197,194.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 7,597,194.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 600,000.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 32,448,321.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 32,448,321.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 39,700.00 | 00.00 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 39,700.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 4,406,970.61 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 4,406,970.61 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,390,000.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,390,000.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,390,000.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,390,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,390,000.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-9,390,000.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **285,452,863.00** | **328,014,360.15** | **-231,049,650.38** | **00.00** | 382,417,572.77 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **285,452,863.00** | **328,014,360.15** | **-231,049,650.38** | **00.00** | 382,417,572.77 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,148,657,932.24 | 00.00 | 1,148,657,932.24 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **285,452,863.00** | **328,014,360.15** | **917,608,281.86** | **00.00** | 1,531,075,505.01 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 637,583,700.00 | 633,149,749.39 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 637,583,700.00 | 633,149,749.39 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 636,983,700.00 | 632,549,749.39 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 406,866,500.00 | 406,858,786.39 |
| 210101 | Үндсэн цалин | 242,770,800.00 | 242,770,799.53 |
| 210102 | Нэмэгдэл | 120,750,100.00 | 120,747,111.71 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,930,000.00 | 6,925,731.13 |
| 210104 | Урамшуулал | 36,415,600.00 | 36,415,144.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54,926,900.00 | 50,964,158.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,652,300.00 | 34,868,857.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,068,700.00 | 4,068,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,254,900.00 | 3,157,559.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 813,700.00 | 889,463.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,137,300.00 | 7,979,579.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 61,886,600.00 | 61,875,890.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,394,800.00 | 2,282,894.00 |
| 210302 | Түлш, халаалт | 58,851,800.00 | 58,841,090.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 640,000.00 | 751,906.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,637,600.00 | 25,592,170.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 800,000.00 | 800,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,767,600.00 | 19,767,570.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 540,000.00 | 495,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,530,000.00 | 2,529,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 63,510,000.00 | 63,506,875.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 53,384,100.00 | 53,383,675.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,145,900.00 | 8,143,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,980,000.00 | 1,980,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,400,000.00 | 14,398,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,900,000.00 | 5,898,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,500,000.00 | 8,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 546,000.00 | 546,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 546,000.00 | 546,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,210,100.00 | 2,812,860.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 515,000.00 | 353,295.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 160,000.00 | 95,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 72,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,306,800.00 | 1,306,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 110,800.00 | 86,965.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 350,000.00 | 220,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 445,500.00 | 445,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6000000.00 | 5995010.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,000,000.00 | 5,995,010.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 600000.00 | 600000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | 600,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 600,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 637,583,700.00 | 633,149,749.39 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 568,753,000.00 | 564,346,029.39 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 568,753,000.00 | 564,346,029.39 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 68,830,700.00 | 68,803,720.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 68,830,700.00 | 68,803,720.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 00.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 30 | 30 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 24 | 24 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05 | 05 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **30** | **30** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 17 | 17 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 13 | 13 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 400,500.00 | 9986452.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 400,500.00 | 9986452.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 400,500.00 | 2389258.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 400,500.00 | 2389258.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 400,500.00 | 2389258.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **7597194.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 7,597,194.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 400500.00 | 9986452.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 400,500.00 | 9986452.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 9,679,252.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 400,500.00 | 307,200.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянцагаан сумын сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Т.Одонтунгалаг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 20–ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянцагаан сумын сум дундын эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 13-ны өдрийн 1/02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянцагаан сумын сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг “Эмнэлгийн тусламж үйлчилгээг ард иргэдэд жигд хүртээмжтэй түргэн шуурхай чанартай хүргэх” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянцагаан сумын сум дундын эмнэлгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянцагаан сумын сум дундын эмнэлгийн санхүүгийн болон шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн төвшнийг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 709464,9 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 14189,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг багасгах шаардлага гараагүй.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянцагаан сумын сум дундын эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1531506,5 мянган төгрөг болж өмнөх оноос 1148902,3 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 27,994.6 | 28,176.9 | 182.3 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 51.2 | 268.5 | 217.3 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 27,943.4 | 27,908.4 | (35.0) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 354,609.6 | 1,503,329.6 | 1,148,720.0 |
| Үндсэн хөрөнгө | 527,758.3 | 1,733,438.1 | 1,205,679.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | (173,148.7) | (230,108.4) | (56,959.7) |
| **Нийт хөрөнгө** | 382,604.2 | 1,531,506.5 | 1,148,902.3 |
| Өр төлбөр | 186.6 | 431.0 | 244.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 382,417.6 | 1,531,075.5 | 1,148,657.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 382,604.2 | 1,531,506.5 | 1,148,902.3 |

Тухайн байгууллага нь өмнөх онд 51,2 мянган төгрөгийн авлагатай байсныг барагдуулсан бол тайлант онд цалингийн зардлыг алдаатай тооцоолсноос шалтгаалж 268,5 мянган төгрөгийн цалинг илүү олгож авлагын залруулга хийгдэв.

Бараа материалын дансны үлдэгдэл 27908,4 мянган төгрөг болж өмнөх оноос 35,0 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны өмнөх оны үлдэгдэл 527758,3 мянган төгрөг байсан бол тайлант оны эцэст 1733438,1 мянган төгрөг болж 1205679,7 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 2 давхар 752 метр квадрат 1183500,0 мянган төгрөгийн өртөг бүхий 15 ортой эмнэлгийн барилгыг бүртгэсэн байна. Мөн ОНХС-гийн хөрөнгөөр 8500,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ЭМГ-аас 9337,7 мянган төгрөг үнэ төлбөргүй авсан байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Засгийн газрын оролцоо дансны өмнөх оны үлдэгдэл 328014,4 мянган төгрөг байсан бөгөөд тайлант онд тухайн дансанд өөрчлөлт гараагүй байна.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх онд 566114,6 мянган төгрөг байсан бол тайлант онд 1858122,8 мянган төгрөг болж 1292008,2 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт нь 596751,4 мянган төгрөгөөс 1210579,6 мянган төгрөг болж 1190856,4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь эмнэлгийн барилгыг үнэ төлбөргүй орлогоор авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх онд 580684,1 мянган төгрөг байсан бол тайлант онд 709464,9 мянган төгрөг болж 128780,8 мянган төгрөгөөр буюу 22,1 хувиар өссөн байна.

Энэ нь тайлант хугацаанд цалингийн зардал өмнөх оноос 63670,7 мянга, ЭМНДШ 7200,2 мянга, түлш халаалтын зардал 22752,8 мянга, эм, эмнэлгийн хэрэгсэл 25697,8 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 761477,1 мянган төгрөгөөр төсөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 137393,2 мянган төгрөгөөр бууруулж 624083,9 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүргүүлсэн саналаас гол буурч батлагдсан зардал нь цалин болон ажил олгогчоос төлөх НДШ 71541,0 мянга, шуудан холбоо 2335,0 мянга, хоол хүнсний зардал 8679,7 мянга, урсгал засварын зардал 15985,0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант оны эхэнд анх 624083,9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 13499,8 мянган төгрөг нэмж тодотгож 637583,7 мянган төгрөг болсон байна. Гол өөрчлөлт орсон зардал нь эмийн зардалд 27379,9 мянган төгрөг нэмж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 8900,0 мянган төгрөг хассан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 637583.7 мянган төгрөгийн төсөв баталсныг улсын төсвөөс 568753,0 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 68803,7 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн авч ЭМДС-гаас 27,0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу буюу 68803,7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 633149,7 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 4407,0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 633149,7 мянган төгрөг буюу 99,3 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх ЭМНДШ 3962,7 , бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 397,2 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | | | | |
| **АРГА ХЭМЖЭЭ 80101** | | | | |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **637,583,700.00** | **633,149,749.39** | **4,433,950.61** | **99.30** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **637,583,700.00** | **633,149,749.39** | **4,433,950.61** | **99.30** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **637,583,700.00** | **633,149,749.39** | **4,433,950.61** | **99.30** |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 406,866,500.00 | 406,858,786.39 | 7,713.61 | **100.00** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,926,900.00 | 50,964,158.00 | 3,962,742.00 | **92.79** |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 61,886,600.00 | 61,875,890.00 | 10,710.00 | **99.98** |
| Хангамж, бараа материалын зардал | 25,637,600.00 | 25,592,170.00 | 45,430.00 | **99.82** |
| Нормативт зардал | 63,510,000.00 | 63,506,875.00 | 3,125.00 | **100.00** |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 14,400,000.00 | 14,398,000.00 | 2,000.00 | **99.99** |
| Томилолт зочны зардал | 546,000.00 | 546,000.00 | - | **100.00** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | 3,210,100.00 | 2,812,860.00 | 397,240.00 | **87.63** |
| **АРГА ХЭМЖЭЭ 80102** | | | | |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,000,000.00** | **5,995,010.00** | **4,990.00** | **99.92** |
| **Хөтөлбөр төслийн дотоод урсгал 83112** | **6,000,000.00** | **5,995,010.00** | **4,990.00** | **99.92** |
| Урсгал засвар | | | | |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 6000000.00 | 5995010.00 | 4,990.00 | **99.92** |
| **Ажил олгогчоос олгох тэтгэмж, 80802** | | | | |
| **Төсвөөс санхүүжих** | **600,000.00** | **600,000.00** | **-** | **100.00** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **600,000.00** | **600,000.00** | **-** | **100.00** |
| Нэг удаагийн тэтгэмж, шаг урам | 600,000.00 | 600,000.00 | - | **100.00** |

## Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 7880,3 мянга, сорьц тээвэрлэлтийн хөлс 307,2 мянга, дээд шатны төсөв захирагчаас 1799,0 мянган төгрөг тус тус төвлөрч зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 136, хугацаа хоцроосон 19 мэдээ байна. Шилэн дансанд дараа жилийн төсвийн төсөл, улирлын болон жилийн эцсийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, хандив тусламжийн жилийн эцсийн мэдээ, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг 7 төрлийн мэдээг байршуулаагүй байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Байршуулаагүй | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 2 | 1 | 6 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 0 | 1 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 31 | 5 | 0 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 83 | 13 | 0 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 136 | 19 | 7 | 2 |

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн дансанд 7 төрлийн мэдээг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгөв.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлангийн уялдаа шалгах хүснэгтээр шалгахад ЭМГ-аас үнэ төлбөргүй ирсэн эмийн 8241,9 мянган төгрөгийн зардлыг ангилал зөрүүтэй илэрхийлсэн нь УСНББОУС 1 - Санхүүгийн тайлангийн толилуулга, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 3-д заасан "Зардал" гэсэн заалтыг баримтлаагүй тул үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэсэн 8241,9 мянган төгрөгийн зардлыг эмийн зардалд залруулав.
2. Цалингийн зардлаар 406672,1 мянган төгрөг байгаа бөгөөд цалинг давтан тооцоолоход 1300,0 мянган төгрөгийн урьдчилгааг шууд зардалд бичиж, албан хаагчаас тухайн урьдчилгааг суутгахдаа нийт бодогдсон цалинг бууруулж бичилт хийснээс ЭМД, татвар шимтгэл суутгаагүйг 431,0 мянган төгрөгийн өглөг 268,5 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд залруулав.
3. Төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахдаа 9986,4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого зарлагыг цэвэрлээгүй тул төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулав.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар үнийн дүнгүй 1 зөрчил илэрсэнд албан шаардлага өглөө. Үүнд:

Шилэн дансанд дараа жилийн төсвийн төсөл, улирлын болон жилийн эцсийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, хандив тусламжийн жилийн эцсийн мэдээ, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг 6 төрлийн мэдээг байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16811,7 мянган төгрөгийн 2 гүйлгээ байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1-д заасан "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" .. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Мэдээг нөхөн байршуулах албан шаардлага өгөв.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

**3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР: Б.АЗБАЯР 2021.02.20
АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ 2021.02.20
ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ 2021.02.20

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Хавсралт: 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 он | | | БНА-2021/168/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тайлангийн уялдаа шалгах хүснэгтээр шалгахад 8241,9 мянган төгрөгийн зардлыг ангилал зөрүүтэй илэрхийлсэн байна. | 8241,9 | Санхүүгийн тайланд залруулах | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Т.Одонтунгалаг, П.Эрдэнэчимэг |
| 2 | Цалингийн зардлаар 406672,1 мянган төгрөг байгаа бөгөөд цалинг давтан тооцоолоход 1300,0 мянган төгрөгийн урьдчилгааг шууд зардалд бичиж, албан хаагчаас тухайн урьдчилгааг суутгахдаа нийт бодогдсон цалинг бууруулж бичилт хийснээс ЭМД, татвар шимтгэл суутгаагүйг 431,0 мянган төгрөгийн өглөг 268,5 мянган төгрөгийн авлага тусгаагүй. | 699,5 | Санхүүгийн тайланд залруулах | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Т.Одонтунгалаг, П.Эрдэнэчимэг |
| 3 | Төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахдаа 9986,4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого зарлагыг цэвэрлээгүй | 9986,4 | Санхүүгийн тайланд залруулах | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Т.Одонтунгалаг, П.Эрдэнэчимэг |
| 4 | Шилэн дансанд дараа жилийн төсвийн төсөл, улирлын болон жилийн эцсийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, хандив тусламжийн жилийн эцсийн мэдээ, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг 6 төрлийн мэдээг байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16811,7 мянган төгрөгийн 2 гүйлгээ байршуулаагүй байна. | 0 | Албан шаардлага өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Т.Одонтунгалаг, П.Эрдэнэчимэг |
| | **ДҮН** | **18927,8** | | | |

- оОо -